

Ипотекийн зээлийн тайлан

2014 оны 2 дугаар сар

Банкууд 2014 оны 2 дугаар сард нийт 1475 зээлдэгчид 81.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2121.8¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 53611 хүрчээ².

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 6.9 нэгж хувиар, оны эхнээс 13.5 нэгж хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 115.5 нэгж хувиар нэмэгдсэн байна.



Ипотекийн зээлийн өсөлт жилийн 8 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оны 6 сараас хурдассан байна. Тодруулбал, банкуудын ипотекийн зээлийн 2014 оны 2 дугаар сарын үлдэгдэл хөтөлбөр хэрэгжиж

эхлэхээс өмнөх үетэй (2013 оны 5 дугаар сар) харьцуулахад 2.2 дахин нэмэгдсэн байна.



Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 65.1 хувь буюу 1382.1 тэрбум төгрөгийг жилийн 8 хувийн хүүтэй хөтөлбөрийн зээл (8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 31.4 хувь буюу 665.2 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 3.5 хувь буюу 74.5 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.


2014 оны 2 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 96.9 хувь нь төгрөгийн зээл, 3.1 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь харьцангуй тогтвортой байна.

¹ МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

² Зарим банкны хашаа байшин худалдаж авах зориулалттай зээлийг 2014 оны 2 дугаар сараас Ипотекийн зээлийн тайланд оруулах болов. 2014 оны 2 дугаар сарын байдлаар уг зээлийн үлдэгдэл 36.1 тэрбум төгрөг байв.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь



Тайлант сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 0.5 хувь, чанаргүй зээлийнх 0.3 хувь байна.

Тайлант сард олгосон зээл

Тухайн сард банкуудын олгосон ипотекийн зээл өмнөх сараас 20 хувиар буурсан ч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өссөн байна.




Тайлант сард шинээр олгосон зээлийн 72.6 хувь буюу 59.0 тэрбум төгрөг нь жилийн 8 хувийн хүүтэй хөтөлбөрийн зээл, 27.4 хувь буюу 22.2 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2010 оны дунд үеэс тогтвортой өссөн бөгөөд 2014 оны 2 дугаар сарын байдлаар 55.1 сая төгрөгт хүрчээ.



Тухайн сард 19.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 9.0 хувиар буурсан ч, өмнөх оны мөн үеэс 1.9 дахин өссөн байна.

Тухайн сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1475 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1093 иргэн 8 хувийн хүүтэй Засгийн газрын хөтөлбөрийн зээлд хамрагдаж, 382 иргэнд банкууд өөрийн эх үүсвэрээс зээл олгожээ.



2014 оны 2 дугаар сарын байдлаар нийт 53611 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 33346 нь жилийн 8 хувийн хүүтэй хөтөлбөрийн зээлд, 18100 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2165 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.1 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2014 оны 2 дугаар сарын байдлаар 14.8 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 46.2 хувь 16-20 жилийн хугацаатайгаар

олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн дийлэнх (40.2 хувь) нь 11-15 жилийн хугацаатайгаар олгогджээ.



Зээлийн хүү

Банкуудын 2014 оны 2 дугаар сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 26.4 хувь, хамгийн бага нь 6.0 хувь байв. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 9.9 хувьтай байсан нь өмнөх сараас 0.1 хувиар өссөн байна. Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.7 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.1, валютаар олгосон зээлийнх 11.6 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

| Он | Сар | Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.) | Үүнээс: | Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар) | Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү, жилээр (%) | Нийт зээлдэгч (тоогоор) |
|------|-----|---------------------------------------|--------------------------------|--|---|-------------------------|
| | | | 8%-ийн хүүтэй хөтөлбөрийн зээл | | | |
| 2008 | 12 | 217,977.5 | | 100.7 | 19.8 | 16,522 |
| 2009 | 12 | 226,040.6 | | 103.4 | 18.7 | 16,784 |
| 2010 | 12 | 333,776.6 | | 115.0 | 16.0 | 16,700 |
| 2011 | 12 | 669,662.8 | | 154.3 | 14.8 | 26,869 |
| 2012 | 12 | 845,204.4 | | 155.5 | 15.3 | 29,887 |
| 2013 | 1 | 856,633.6 | | 149.1 | 17.0 | 29,683 |
| | 2 | 873,666.4 | | 156.1 | 16.8 | 29,946 |
| | 3 | 903,557.5 | | 158.6 | 15.7 | 30,419 |
| | 4 | 944,516.8 | | 155.4 | 15.8 | 31,412 |
| | 5 | 986,182.2 | | 147.8 | 16.6 | 32,247 |
| | 6 | 1,032,156.7 | 276,328.4 | 168.3 | 12.9 | 33,028 |
| | 7 | 1,273,003.6 | 553,346.9 | 202.4 | 9.2 | 37,751 |
| | 8 | 1,461,753.4 | 781,483.2 | 207.6 | 8.9 | 40,596 |
| | 9 | 1,611,383.8 | 943,976.7 | 206.0 | 9.1 | 42,968 |
| | 10 | 1,750,781.6 | 1,076,924.5 | 193.9 | 9.6 | 45,138 |
| | 11 | 1,834,042.7 | 1,155,409.2 | 192.8 | 9.7 | 46,482 |
| | 12 | 1,938,945.3 | 1,248,633.8 | 192.8 | 9.9 | 48,320 |
| 2014 | 1 | 2,021,424.9 | 1,324,898.9 | 194.4 | 9.8 | 49,731 |
| | 2 | 2,121,802.6 | 1,382,084.1 | 193.2 | 9.9 | 53,611 |